

“АДУУНЧУЛУУН” ХК

2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

ЗААСУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН О.ГАНГАМӨРӨН

**“АДУУНЧУЛУУН” ХК-ИЙН 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Манай компани 2019 оны 2-р улиралд 276.0 мян.тн нүүрс олборлох, 302.0 м³ хөрс хуулах, нийт 533.9 мян.м³ уулын цулын ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2019 оны 2-р улиралд нийт 276.0 мян.тн нүүрс олборлож борлуулахаас 115.9 мян.тн нүүрс олборлож, төлөвлөгөөнөөс 160.1 мян.тн-р буурсан гүйцэтгэлтэй гарч байна.

2018 оны эхний хагас жилтэй харьцуулбал нүүрс олборлолт биет хэмжээгээр 152.3 мян.тн-р буурсан байна.

Үзүүлэлт	Х/нэгж	2018-II	2019-II		Зөрүү		Харьцуулалт /%-иар/	
			төлөв	гүйц	2018-с	төл-с	2017с	төл-с
Нүүрс борлуулалт	мян.тн	268.2	276.0	115.9	-152.3	-160.1	-56.8	-58.0
“ДБЭХС” ХК	мян.тн	235.0	246.0	103.9	-131.1	-142.1	-55.8	-57.8
Ахуй	мян.тн	33.2	30.0	12.0	-21.2	-18.0	-63.9	-60.0
Хөрс хуулалт	мян.м3	228.3	302.0	841.1	612.8	539.1	0.0	0.0
Уулын цул		453.7	533.9	938.5	484.8	404.6	106.9	75.8

“ДБЭХС” ТӨХК-д гэрээний дагуу 246.0 мян.тн нүүрс нийлүүлэхээс 103.9 мян.тн-ыг нийлүүлж, төлөвлөснөөс 142.1 мян.тн-р буурч, ахуйн хэрэглэгчдэд 30.0 мян.тн-ыг нийлүүлэхээс 12.0 мян.тн-ыг нийлүүлж, төлөвлөснөөс 18.0 мян.тн-р буурсан байна.

Нүүрсний нийт олборлолтын 89.4%-ийг “ДБЭХС” ХК-д, 10.6%-ийг айл өрх, ААНэгжүүдэд борлуулсан.

2013-2019 оны 2-р улирал тус бүрээр олборлож борлуулсан нүүрсний хэмжээг дараах графикаар харьцуулж харууллаа. Графикаас харвал 2017 онд “ДБЭХС” ТӨХК-д, 2018 онд айл өрх, албан байгууллагуудад хамгийн их хэмжээгээр борлуулалт тус тус хийсэн байна. 2019 онд хийгдсэн борлуулалт өмнөх онтой харьцуулбал буурсан үзүүлэлттэй харагдаж байна.



2019 оны 2-р улиралд ДБЭХС ТӨХК-д, ААН, айл өрхүүдэд 276.0 мян.тн нүүрс нийлүүлэх байсан боловч гэрээнд өөрчлөлт орсны улмаас төлөвлөгөөнд хүрээгүй, төлөвлөгөөнөөс 160.1 мян.тн нүүрсээр буурч, өмнөх оноос 152.3 мян.тн нүүрсээр буурсан үзүүлэлттэй байна.



Хөрс хуулалтын ажил өмнөх онуудтай харьцуулсан байдлаар дээрх графикаар харууллаа. Үүнээс харахад 2019 оны 2-р улиралд 280.4 м³ хөрс хуулсан байна. Өмнөх оны мөн үеэс 52.0 м³ өссөн харагдаж байна.

2. УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2019 оны бүтэц, орон тоогоор 132 байнгын ажлын байранд 128 ажилтан албан хаагчидтай ажиллаж байна.

Компани уул технологи, уул, автозасвар, цахилгаан сантехник, хайгуул олборлолт гэсэн 5 хэсэгтэй.

№	Овог нэр	Албан тушаал
1	Ш.Баясгалан	Гүйцэтгэх захирал
2	Н.Болдрагчаа	Ерөнхий инженер
3	Б.Энхбаатар	Ерөнхий нягтлан бодогч
4	Ю.Лутбаатар	ХАБЭА-н инженер

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

№	Овог нэр	Албан тушаал
1	Б.Шатар	ТУЗ-ийн дарга
2	Б.Батсайхан	ТУЗ-ийн гишүүн
3	Ш.Мягмарсүрэн	ТУЗ-ийн гишүүн
4	Ш.Баясгалан	ТУЗ-ийн гишүүн
5	Ш.Идэр	ТУЗ-ийн гишүүн
6	Ш.Бямбасүрэн	ТУЗ-ийн гишүүн
7	С.Бадарч	ТУЗ-ийн хараат бус гишүүн
8	М.Шинэтогтох	ТУЗ-ийн хараат бус гишүүн
9	Ө.Амаржаргал	ТУЗ-ийн хараат бус гишүүн
10	О.Гангамөрөн	ТУЗ-ийн нарийн бичиг

3. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тайлант хугацаанд нийт 2 006.5 сая.төг-ийн орлого орж, 3 611.2 сая.төг-ийн зардал гаргаж ажилласан. Өнгөрсөн онтой харьцуулбал орлого 2 234.5 сая.төг буюу 52.7 %-иар буурч, зардал 220.7 сая.төг буюу 5.8 %-иар мөн буурсан байна. Иймээс татвар төлөхийн өмнөх ашиг өнгөрсөн оноос 1 604.7 сая.төг-р буурсан үзүүлэлттэй гарч байна.

Үзүүлэлт	Х/нэгж	2018-II	2019-II	Харьцуулалт	
				тоо	%-р
Нийт орлого	сая.төг	4,241.0	2,006.5	-2,234.5	-52.7
Нийт зардал	сая.төг	3,831.9	3,611.2	-220.7	-5.8
ТТӨ ашиг	сая.төг	409.1	-1,604.7	-2,013.8	-492.3

2019 оны 2-р улирлын үйл ажиллагааны зардлыг доорх графикаар харууллаа. Үйл ажиллагааны зардлын 13.4 хувийг түлш, 21.3 хувийг сэлбэг, 28.0 хувийг цалин, 9.0 хувийг элэгдлийн зардал, 28.4 хувийг бусад зардал эзэлж байна.

Үйл ажиллагааны зардал



Компанийн хэмжээнд 1 хүний сарын дундаж цалин 2018 оны 2-р улирлаар 1 293.0 мян.төг байсан бол тайлант хугацаанд дундажаар 1 хүний дундаж цалин 1 348.5 мян.төг байна.

Үйл ажиллагааны нэгжийн өртөг:

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018-II	2019-II	Зөрүү
Нүүрс олборлолт	тн	268.2	115.9	-152.3
Бүрэн өөрийн өртөг	төг	3831.9	3611.2	-220.7
1 тн нүүрсний өртөг	төг	14,287.5	31,157.9	16,870.4

1 тн нүүрсний өртөг 2018 оны 2-р улиралд 14 287.5 төгрөг байсан бол тайлант хугацаанд 31 157.9 төгрөг болж 16 870.4 төгрөгөөр өссөн байна.

Орлого:

Тайлант хугацаанд нийт орлого 2 006.5 сая.төг, үүнээс нүүрсний орлого 1 479.4 сая.төг, тээврийн орлого 397.6 сая.төг, бусад орлого 129.5 сая.төг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт орлого 2 234.5 сая.төг-р буурсан. Үүнээс ахуй хэрэглэгчдийн орлого 295.7 сая.төг-өөр, Станцад нийлүүлсэн нүүрсний орлого 1 649.5 сая.төг-өөр, тээврийн орлого 267.1 сая.төг-өөр, бусад орлого 22.2 сая төг-өөр тус тус буурсан байна.

Гол хэрэглэгч болох ДБЭХС ТӨХК-с нүүрс борлуулалтанд 1 311.5 сая.төг, тээврээс 397.6 сая.төг-ийн орлого, ААНэгж, айл өрхөөс нүүрсний орлого 167.9 сая.төгрөгийн орлого тус тус олсон байна.

Орлогын бууралт нь нүүрсний биет хэмжээний бууралтаас шууд хамааралтай.

- ✓ Өнгөрсөн онтой харьцуулахад “ДБЭХС” ТӨХК-д нийлүүлсэн нүүрсний биет хэмжээ 131.1 мян.тн-р буурсан байна.
- ✓ Ахуйн хэрэглэгчдэд нийлүүлсэн нүүрсний борлуулалт өнгөрсөн онтой харьцуулахад биет хэмжээгээр 21.2 мян.тн-р буурсан.

- ✓ Тээврийн орлого нь станцад нийлүүлсэн нүүрсний биет хэмжээ буурахад дагаж буурсан.

Орлого	Х/нэгж	2018-II	2019-II	Харьцуулалт	
				тоо	%
Нүүрсний борлуулалт	сая.төг	3,424.6	1,479.4	- 1,945.2	- 56.8
Станц	сая.төг	2,961.0	1,311.5	- 1,649.5	- 55.7
Ахуй	сая.төг	463.6	167.9	- 295.7	- 63.8
Тээврийн орлого	сая.төг	664.7	397.6	- 267.1	- 40.2
Бусад орлого	сая.төг	151.7	129.5	- 22.2	- 14.6
Нийт	сая.төг	<u>4,241.0</u>	<u>2,006.5</u>	<u>- 2,234.5</u>	<u>- 52.7</u>

Үр ашиг, алдагдал:

Тайлант хугацаанд үйл ажиллагаандаа нийт 2 006.5 сая.төг-ийн орлого олж, 3 611.2 сая.төг-ийн зардал гаргаж -1 604.7 сая.төгрөгийн алдагдалтай гарсан. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвар төлөхийн өмнөх ашиг -1 604.7 сая.төг-р буурч алдагдал хүлээж байна.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018-II	2019-II	Харьцуулалт	
				зөрүү	%
Нийт орлого	сая.төг	4,241.0	2,006.5	-2,234.5	-52.7
Нийт зардал	сая.төг	3,831.9	3,611.2	-220.7	-5.8
Татвар төлөхийн өмнөх ашиг	сая.төг	409.1	-1,604.7	-2,013.8	-492.3
Орлогын татварын зардал	сая.төг	40.9	0.0	-40.9	-100.0
Татварын дараах ашиг	сая.төг	368.2	-1,604.7	-1,972.9	-535.8

4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Компанийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн талаарх мэдээлэл

№	Овог нэр	Эзэмшиж буй хувьцаа
1	Б.Шатар	51%
2	Ж.Сайнтуяа	18%
3	Ц.Шинэбаяр	18%

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Дорнод аймаг, Хэрлэн сум, 8-р баг, компанийн өөрийн байранд 14:00 цагт хийж дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэв.

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт.
2. Нэгж хувьцаанд ногдол ашиг хувиарлах хэмжээ батлах, тараах хугацааг тогтоох тухай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

4. Бусад асуудал /КтХ-ийн 62.1 дэх заалт/

5. НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Компани 2018 оны үйл ажиллагааны ашгаас 2019 онд нэгж хувьцаанд 130 төгрөг хувиарлах шийдвэр гаргаж нийт 409,7 сая төгрөгийн ногдол ашгийг хувиарлаад байна.